



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 07 өдөр

Дугаар 15/2020

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ийн "б", Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 3.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай 78 дугаар зүйлийн 78.2.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант ойн төгөл хоршооны хийж гүйцэтгэсэн Буянт голын автомашины гарам хаах ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Х.Баярлах

-Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд:

Ц.Сувдаа

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Э.Саранцэцэг

- Жаргалант сумын нийгмийн ажилтан

Ц.Даваасамбуу

-Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн

С.Батдорж

-Аймгийн архивын тасгийн дарга

Ц.Түмэндэмбэрэл


-Жаргалант ойн төгөл хоршооны дарга

Нарийн бичгийн
дарга:
М.Баяржаргал

-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын
газрын Барилга хот байгуулалтын
хэлтсийн мэргэжилтэн

2. Жаргалант ойн төгөл хоршооны хийж гүйцэтгэсэн ажлыг 2020 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн дотор багтаан захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган, шалгаж өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Х.Баярлах/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН